



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамрагдсан байгууллага: ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЖАНГАР НИЙТИЙН НОМЫН
САН

Тайлангийн код: СХШУДАГ-2026/ДА/07

Говь-Алтай аймаг
2026 он

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай.....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	3
2.1. Аудитын зорилго.....	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.....	3
2.3. Аудитын арга, аргачлал	3
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА	3
3.1. Засаглалын удирдлагын талаар	4
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар.....	4
3.3. Дотоод хяналтын талаар.....	4
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	5
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;.....	6
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;.....	7
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;.....	7
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах; 7	
5. АУДИТЫН ҮР ДҮН.....	8
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	11

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 “Яам нь харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.” Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Говь-Алтай аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, дотоод аудитор, ахлах мэргэжилтэн Ч.Одгэрэл 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 29-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын зөвлөлийн 54 дүгээр тогтоолоор нийтийн номын санг 1 орон тоотой, 200 номтойгоор 1944 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 60 дугаар тогтоолоор ахмад зохиолч, хувьсгал тэмцлийн ахмад зүтгэлтэн Дэгээхүүгийн Сүрьяа агсны нэрэмжит болгосон. Улмаар аймгийн засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/707 дугаар захирамжаар “Жангар нийтийн номын сан” болон өөрчлөгдсөн байна.

Жангар нийтийн номын сан нь 1 дүгээр давхар 389.7м², 2 дугаар давхар 483.7 м² талбай бүхий нийт 873.4 м² бүхий талбайд 2019 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн шинэ ашиглалтад орсон өөрийн байрандаа үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус номын сан нь 19 нэр төрлийн 43900 гаруй номын фондтой, жилд 10-12 нэр төрлийн тогтмол хэвлэл захиалан нэгж болгон үдэж уншлага үйлчилгээнд гарган, үндсэн фонд, уншлага үйлчилгээний 5 танхимтайгаар үйл ажиллагаагаа явуулж үйлчлүүлэгчдээ хүрч ажиллаж байна. Мөн 18 сумын соёлын төвийн болон 5 ерөнхий боловсролын сургуулийн номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг байна.

Байгууллагын регистрийн дугаар 9015078, Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны 1000535022, орон нутгийн 10050035011 дүгээр харилцах дансаар бэлэн бус төлбөр, тооцоог хийсэн.

Аудитад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дарга Я.Одгэрэл, хоёрдугаар гарын үсгийг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс нягтлан бодогч С.Долгормаа нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийн, дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Үүнд.

- Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;
- Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;
- Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;
- Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах;

Хязгаарлалт: Дээрх асуудлаас бусад үйл ажиллагааг хязгаарласан болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгосон. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Жангар нийтийн номын сан нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу орчин үеийн жишиг номын сан болох “Чимээтэй номын сан” болон өргөжихөөр нийт 487,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг эхлүүлэхээр зураг төсвөө батлуулсан байна. Орон нутгийн төсвөөр 2026 онд номын сангийн нэгдүгээр давхрын 389.7 м² талбайд 267,000.0 мянган төгрөгөөр засвар үйлчилгээний ажил эхлэхэд бэлэн болсон байна.

Мөн үр дүнд суурилсан санхүүжилтээр 2024 онд ном ариутгагч төхөөрөмж худалдан авч, номын сангийн бүртгэлтэй номыг бүрэн ариутгалд оруулсан байна.

3.1. Засаглалын удирдлагын талаар

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 415 дугаар тушаалаар номын сангийн үлгэрчилсэн дүрэм баталсан бөгөөд үүний дагуу “Нийтийн номын сангийн дүрэм”-ийг 5 бүлэг 35 заалттай байхаар захирал 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр баталсан байна. Тус дүрмийн 1.1-д *“Аймаг, нийслэлийн нийтийн номын сан нь бие даасан үйл ажиллагаатай, иргэдэд ном, хэвлэл мэдээллээр үйлчлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах үүрэг бүхий орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллага мөн”* гэж заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргаар байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллажээ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хэмжээнд 49 арга хэмжээ төлөвлөгдсөн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 27, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 24 нийт 51 тушаал шийдвэрийг төлөвлөн гаргасан байна. Төлөвлөн гаргасан зарим тушаал шийдвэрийн үндэслэх хэсэг нь хууль эрх зүйн хүрээнд төлөвлөн гаргаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэг”-ийн нэгдсэн дүнгээр 85 хувьтай дүгнэгдсэн байна.

Жангар нийтийн номын сангийн бүтэц орон тоо 2026 оны байдлаар захирал-1, гэрээт нягтлан бодогч, арга зүйч-1, ном зүйч-1, сан хөмрөгч-1, номын санч-4, мэдээлэл технологийн ажилтан-1, аж ахуй үйлчилгээний нярав-1, үйлчлэгч-1, жижүүр-4 гэсэн нийт 15,5 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Захирлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Нийтийн номын сангийн бүтэц орон тоог батлах тухай” А/159 дүгээр тушаалаар 14 хүний орон тоотой байхаар баталсан байна. Аудитад хамрагдах хугацаанд 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй. Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 8 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан *“Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”*-ын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх эрх бүхий дотоод хяналт шалгалтын комиссыг захирлын 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Комиссын гишүүнд жижүүр оруулсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд нийт 11 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт гаргаагүй, төлөвлөгөөнд тусгасан дотоод хяналт шалгалт хийх ажлууд нь тодорхой бус утга найруулгын алдаатай байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал: Байгууллагын санхүү байдлын тайлангаар нийт хөрөнгө 2025 онд 1,485,639.1 мянган төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлан *Хүснэгт 1 (мянган төгрөг)*

Үзүүлэлт	2025 оны 12 сарын 31		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/
1	2	3	4
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	23,930.4	34,337.7	10,407.3
Бараа материал	24,214.3	26,734.5	2,520.2
Үндсэн хөрөнгө	1,458,249.9	1,424,566.9	(33,683.0)
Нийт хөрөнгө	1,506,394.6	1,485,639.1	(20,755.5)
Нийт өр төлбөр	32,438.9	48,112.5	15,673.6
ЗГ-ын оруулсан капитал	1,473,955.7	1,437,526.6	(36,429.1)
Өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн	1,506,394.6	1,485,639.1	(20,755.5)

Авлага дансны үлдэгдэл 10,407.3 мянган төгрөгөөр өсөж нийт 34,337.7 мянган төгрөг болсон нь цалингийн нөхөн олговортой холбоотой олон жилийн насжилттай авлага байна.

Үйл ажиллагааны санхүүжилтийн талаар:

Байгууллагын төсвийг нийт 595,486.1 мянган төгрөгөөр баталсан. Үүнээс улсын төсвөөс 515,296.8 мянган төгрөг, орон нутгаас 80,189.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Гүйцэтгэлээр 593,202.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсөвт хөрөнгийн зарцуулалтын талаар:

Төсвийн гүйцэтгэл

Хүснэгт 2(мянган төгрөг)

№	Эх үүсвэр	2025 оны 12 сарын 31		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	595,486.1	593,202.5	99.6
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,562.7	580,923.1	99.9
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,663.2	417,356.3	99.9
4	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	52,207.9	52,109.9	99.8
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,189.3	80,189.3	100
6	Хангамж, бараа материалын зардал	6,679.7	6,492.6	97.2
7	Эд хогшил урсгал засвар	6,448.8	6,448.0	100
8	Томилот зочны зардал	1,500.0	1,500.0	100
9	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	11,479.0	11,432.0	99.6
10	Бараа үйлчилгээний зардал	5,394.9	5,394.9	100
11	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	13,923.4	12,279.4	88.2
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	595,486.1	593,202.5	99.6
13	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	515,296.8	515,296.8	100
14	Үйл ажиллагааны орлого		1,902.5	
15	Туслах ажиллагааны орлого ЗДТГ азар		3,979.0	
16	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		2,600.0	

17	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,189.3	80,189.3	100
----	-----------------------------------	----------	----------	-----

4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 24,214.3 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 26,734.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал			Хүснэгт 3 (мянган төгрөг)		
Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Тусгай зориулалтын материал	755,5	5,637.0	1,195.3	5,198.1
2	Бичиг хэргийн материал	267,8	698,5	716,8	249,5
3	Аж ахуйн материал	15092.0	1,912.8	2,878.3	14,126.5
4	Шатахуун	0	224,5	224,5	0
5	Барилгын засварын материал	6,480.0			6,480.0
6	Бусад хангамжийн материал	1,619.0		938,5	680,5
Дүн		24,214,3	8,473,7	5,953.4	26,734.5

Нийт бараа материалын 52,8 хувийг аж ахуйн материал, 19.4 хувийг тусгай зориулалтын материал, 24.2 хувийг барилгын засварын материал үлдсэн 3,6 хувийг бусад бараа материал эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,473.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 3,967.4 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэн зарцуулж, 1,966.0 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 1,628,982.6 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 1,424,566.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө			Хүснэгт 4(мянган төгрөг)				
Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Барилга	1,321,637.5	0	-	1,321,637.5	125,349.4	1,196,288.1
2	Машин тоног төхөөрөмж	52,649.6	10,242.9		62,892.5	38,098.9	24,793.6
3	Тавилга эд хогшил	55,922.6			55,922.6	36,895.6	19,027.0
4	Номын фонд	116,893.1	6,705.8		123,598.9		123,598.9
5	Бусад үндсэн хөрөнгөнөм	55,640.3		7,800.9	47,839,3		47,839.3
6	Бусад биет бус хөрөнгө	18,860.0		6,640,0	12,020.0		12,020
7	Программ хангамж	7,579.5			7,579.5	6,579.0	1,000.0
Дүн		1,628,982.6	16,948.7	14,440.9	1,631,490.4	36,190.7	1,424,566.9

Нийт хөрөнгийн 84,0 хувийг барилга, 8,6 хувийг номын фонд, 1,7 хувийг машин тоног төхөөрөмж, 1,3 хувийг тавилга эд хогшил, үлдсэн 4,4 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,329.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 5,824.8 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна. Мөн Соёл, спорт, аялал

жуулчлал, залуучуудын яамнаас 2024 онд 3,794.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр орлого авч 2025 онд бүртгэсэн байна.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7,800.9 мянган төгрөгийн 4941 ширхэг номыг акталсан байна. Ингэхдээ мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргаагүй байна.

4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Тус байгууллага нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Говь-алтай аймгийн Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 3 нэр төрлийн алдаа зөрчил илэрч 1 зөрчлийг залруулж, 1 акт, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна. Тайлант 2025 онд залруулаагүй зөрчилгүй учир “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байна.

Төрийн аудитаас 2024 онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж

Хүснэгт 5 (мянган төгрөг)

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн байдал
Акт	Манлай Алтай ХХК-аар хийлгэсэн вакуум цонх нь ажлын даалгавраас 4 мкв цонхыг дутуу хийсэн, ажлыг хүлээн авсан акт, тайлан байхгүй, гэрээг дүгнээгүй.	1,100.0	Төрийн сан хүү торгуулийн дансанд тушааж, зөрчлийг арилгасан. Давтан гаргаагүй байна.
Албан шаардлага	Цахим дэлгүүрээс компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй.	3,900.0	Зөрчлийг арилгаж, давтан гаргаагүй байна.
	Нийт	5,000.0	

4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 6 мэдээ хугацаа хоцроосон.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалын хавсралтаар “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийг баталсан.

Дээрх аргачлалын дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн хуваарилалт батлах тухай” А/212 дугаар тушаалаар төсвийн хуваарилалтыг баталж, тайлант онд нийт 12,649.6 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр 12,645.9 мянган төгрөгийг зарцуулж, 3.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлэг хийсэн байна. сан байна. Зарцуулалтыг хөтөлбөр арга хэмжээгээр авч үзвэл

- ✓ Хөтөлбөр арга хэмжээнд 3,794.9 мянган төгрөг;
- ✓ Байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт буюу компьютер тоног төхөөрөмж 5,059.0 мянган төгрөг;
- ✓ Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,897.4 мянган төгрөг;
- ✓ Урамшуулал олгоход 1,894.6 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн зарцуулалтаар илэрсэн алдаа дутагдал илрээгүй болно.

5. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Жижиг мөнгөн сангийн дансгүй, үйлчилгээний орлогыг бэлнээр хүлээн авч, төвлөрүүлдэг, журмын дагуу зарцуулалтын тайлан гаргаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Жижиг мөнгөн сангийн дансгүй, үйлчилгээний орлогыг бэлнээр хүлээн авч, төвлөрүүлдэг. Тайлант онд төлбөрт үйлчилгээний орлого 1,983.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс нийт 1,902.5 мянган төгрөгийг бэлнээр хүлээн авч төвлөрүүлсэн, 80.5 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1 "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банкт хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2 "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна", 3.6.6 "Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна"; 3.6.10 "Төсвийн байгууллага нь мөнгөн кассата бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" 3.6.8. "Төсвийн байгууллага нь ЖМС-ийн хөрөнгийн зарцуулалтын тайланг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гарган картын дансны дэлгэрэнгүй хуулга, холбогдох үндэслэх баримтын хамт харьяа төрийн санд хүргүүлэн дараагийн ЖМС авах эрхээ нээлгэж болно".	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Шат шатны хяналт сул.	
Үр нөлөө: Орлого дутуу төвлөрүүлэх, хувьдаа завших нөхцөл бүрдэнэ.	
Зөвлөмж: Төрийн сангийн ЖМС-ын данс нээлгэн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг бүрэн төвлөрүүлэх, орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан тушааж, зарцуулалтын тайланг журамд заасны дагуу гаргах, цаашид үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг бэлнээр хураан авч төвлөрүүлэхгүй.	

Илэрсэн асуудал 2	Захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар батлагдсан бүтэц орон тоонд байхгүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл нийт 565.6 мянган төгрөгийн цалин хөлс олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал: Мэдээллийн ажилтан Э.Оюунсүвдэд бүтэц орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн албан тушаалыг захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл олгосон.
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно. ” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”.
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан бүтэц орон тоог мөрдөөгүй.
Үр нөлөө:Төсвийг хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулах.
Зөвлөмж: Батлагдсан бүтэц орон тоог мөрдөж ажиллах.

Илэрсэн асуудал 3	Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулахгүйгээр нийт 7,800.9 мянган төгрөгийн үнэ бүхий 4941 ширхэг номыг акталж данс бүртгэлээс хассан.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Захирлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн өдрийн “Үндсэн хөрөнгө актлах тухай” А/20 дугаар тушаалаар үндсэн хөрөнгийн номын фонд, бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4941 ширхэг 7,800.9 мянган төгрөгийн үнэ бүхий номыг агуулга хуучирсан, дахин ашиглах боломжгүй гэх тайлбартайгаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулахгүйгээр данснаас акталсан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт хангалтгүй.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 65 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж, төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна”, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7 “үндсэн хөрөнгөд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулна.” заалтуудад нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Шат шатны хяналт сул.	
Үр нөлөө: Хууль, дүрэм журам зөрчигдөнө.	
Албан шаардлага: Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахгүйгээр агуулга хуучирсан тайлбартайгаар номыг акталж данс бүртгэлээс хассан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, холбогдох дүгнэлтийг гаргуулах.	

Илэрсэн асуудал 4	Дотоод хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Байгууллагын бүхий л үйл ажиллагааг хамарсан дотоод хяналт хийгдээгүй. Дотоод хяналт шалгалтын комиссын бүрэлдэхүүнд жижүүр оруулсан. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу удирдамж баталсан боловч хяналт шалгалтыг иж бүрэн гүйцэтгээгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.1 "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах"	
Асуудлын үндсэн шалтгаан: Хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлээгүй.	
Үр нөлөө: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
Зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах. Илэрсэн алдаа дутагдлыг арилгуулан үр дүнг хамт олонд мэдээлж байх.	

Илэрсэн асуудал 5	Байгууллагын нярав тайлант онд 2 удаа солигдсон бөгөөд байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх ажил хүлээлцэх акт үйлдээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Байгууллагын нярав тайлант онд 2 удаа солигдсон бөгөөд байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх ажил хүлээлцэх акт үйлдээгүй.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 12 дугаар зүйл. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого 12.2.2. “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” заалтуудад нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Шат шатны хяналт сул.	
Үр нөлөө: Хууль, дүрэм журам зөрчигдөнө.	
Албан шаардлага: Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахгүйгээр агуулга хуучирсан тайлбартайгаар номыг акталж данс бүртгэлээс хассан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, холбогдох дүгнэлтийг гаргуулах.	

Илэрсэн асуудал 6	Шилэн дансны цахим системд 6 мэдээ хугацаа хоцроосон.
Асуудлын ангилал	Нөлөө багатай.
Бодит байдал: Шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 6 мэдээ хугацаа хоцроосон.	
Шалгуур үзүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтад нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө: Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	

Зөвлөмж: Давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тус байгууллага нь орчин үеийн жишиг номын сан болох “Чимээтэй номын сан” болон өргөжихөөр нийт 487,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсөв батлуулсан байна. Тус ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 267,000.0 мянган төгрөгийг шийдүүлэн 2026 онд номын сангийн нэгдүгээр давхарт засвар үйлчилгээний ажил эхлэхэд бэлэн болсон байна. Мөн үр дүнд суурилсан санхүүжилтээр 2024 онд ном ариутгагч төхөөрөмж худалдан авч, номын сангийн бүртгэлтэй номыг бүрэн ариутгалд оруулсан байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар үндсэн үйл ажиллагаанаас олсон төлбөрт үйлчилгээний орлогыг бэлнээр хураан авч, төвлөрүүлдэг. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахгүйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 4941 ширхэг номыг агуулга хуучирсан, ашиглах боломжгүй шалтгаанаар акталж данс бүртгэлээс хассан, батлагдсан бүтэц орон тоонд байхгүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж нэмэгдэл хөлс олгосон зэрэг нийт 10,349.5 мянган төгрөгийн 6 асуудал илэрсэн. Үүнээс 2,548.5 мянган төгрөгийн 5 асуудалд зөвлөмж, 7,800.9 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж ажиллалаа.

Иймд “Аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудын 25 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн үед өгдөг “Сайжруулах шаардлагатай” үнэлгээг өгөв.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ